



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/212

Чингис хот

Байнгын байршил тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт байрлах Хүдрийн биет 16-2 нэртэй MV-018936 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Түшиг-Интернэшнл” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршлыг хавсралтад заасан солбицлуудаар тогтоосугай.

2. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах аюулгүй ажиллагааг хангаж ажиллахыг “Түшиг-Интернэшнл” ХХК-д зөвлөсүгэй.

3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд бүртгэж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт хяналт тавьж, иргэд аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Д.Баярхүү), Бор-Өндөр сумын Засаг дарга (П.Чинбат) нарт, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, стандартын дагуу тэсэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл хадгалах, агуулах, тээвэрлэх, ашиглах аюулгүйн ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Сүнгээ), Цагдаагийн газрын дарга (Б.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011311

Аймгийн Засаг даргын 2021 оны  
05 дугаар сарын 07 өдрийн А/212  
дугаар захирамжийн хавсралт



“Түшиг-Интернэшнл” ХХК-ийн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын газрын байнгын байршил

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	46	18	01.38	109	24	36.16
2	46	17	59.04	109	24	38.29
3	46	17	57.62	109	24	34.38
4	46	18	00.11	109	24	32.25